



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/46

Хэрлэн сум

Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн
тоо бүртгэл зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалгууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны наймдугаар хуралдааны "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах хүрээнд айл өрх, аж ахуйн нэгжүүд болон хөдөлгөөнт авто тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг цуглуулах, цахим мэдээллийн санд шивж оруулах ажилд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231018193